



“МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ: ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ” СЭДЭВТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн үүсгэн байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан их, дээд сургуулийн оюутнуудын эрдэм шинжилгээний ажил хийх сонирхол, санал, санаачилгыг дэмжих, илтгэх ур чадвар, арга барилыг төлөвшүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, дүгнэлт, саналыг холбогдох байгууллагуудад уламжлах, мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, чиг хандлагыг нийтэд мэдээлэн хүргэхэд оршино.

Хоёр. Зохион байгуулагч

-Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн
-Монголын Хуульчдын холбоо /Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролыг дэмжих хороо, Прокурорын хороо, Эрүүгийн эрх зүйн хороо/

Гурав. Илтгэлийн үндсэн чиглэл

1. Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, төрөл, хэлбэр, онцлог;
2. Монгол Улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, боловсронгуй болгох арга зам;
3. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид мөнгө угаах гэмт хэргийг тодорхойлж байсан түүхэн уламжлал, одоогийн зохицуулалтыг сайжруулах арга зам;
4. Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал, гадаад орны хууль тогтоомжтой харьцуулсан судалгаа;
5. Мөнгө угаах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага;
6. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй хүчин зүйлс;
7. Мөнгө угаах гэмт хэргийн субъектийн онцлог;
8. Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга зам;
9. Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам;
10. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн ойлголт, олон улсын туршлага;
11. Виртуал хөрөнгө ашиглан мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах аргачлал, хүндрэл бэрхшээл, боловсронгуй болгох арга зам;
12. Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик, тулгамдаж буй асуудал;
13. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын болон дотоодын байгууллагуудын хамтын ажиллагааны ач холбогдол;

14. Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавигдах хяналт, комплаенсын үйл ажиллагааг идэвхжүүлэх асуудал;
15. Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэж буй алба хаагчдыг мэргэшүүлэх, сургалтын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, үр дүнг дээшлүүлэх арга зам;
16. Мөнгө угаах, терроризмтой тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах арга зам;
17. Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшин;
18. Мөнгө угаах гэмт хэргийн талаарх статистик мэдээлэл солилцооны өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга зам, олон улсын туршлага.

Дөрөв. Илтгэлийн шалгаруулалт

4.1. Уралдааныг их, дээд сургуулиудын оюутнуудын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 15, 26-ны өдрүүдэд хоёр үе шаттай зохион байгуулна.

4.2. Илтгэлийг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр gpo_tri@prokuror.mn хаягаар хүлээж авна.

4.3. Эхний шатанд ирсэн илтгэлүүдтэй зохион байгуулагчид танилцаж, шаардлага хангасан илтгэлүүдийг эмхэтгэлд оруулахаар шалгаруулна.

4.4. Эмхэтгэлд оруулахаар сонгогдсон илтгэлүүдээс 8 илтгэлийг сонгон шалгаруулж 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн танхимд хэлэлцүүлэх ба илтгэл ирүүлсэн оюутнуудыг тус хэлэлцүүлэгт урилгаар оролцуулна.

4.5. Оюутан илтгэл хэлэлцүүлэх үед илтгэгчийн илтгэх үндсэн хугацаа 15 минут, асуулт, хариултын хугацаа 5 минут байна.

Тав. Илтгэлд тавигдах шаардлага

5.1. Зарласан сэдвийн хүрээнд илтгэлийн сэдвийг сонгосон байх;

5.2. Сонгосон сэдвийн хүрээнд бодит нөхцөл байдал, дэвшүүлж буй шийдлийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байх;

5.3. Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдсан, шинэлэг санаа дэвшүүлсэн байх;

5.4. Илтгэл нь хураангуй, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, иш татсан ном зохиол, бүтээл, судалгаа, эх сурвалжийг тодорхой дурдсан байх;

5.5. Илтгэлийн зохиогч нь нэг буюу хоёр этгээд байж болох ба зохиогчийн нэрийг илтгэлийн эхний нүүрэнд бичсэн байна. Илтгэлийг багшийн удирдлага дор бичиж болно.

5.6. Илтгэл нь зохиогчийн эрхийг зөрчөөгүй байх;

5.7. Илтгэл нь А4 цаасан дээр 5-10 нүүрэнд багтсан, мөр хоорондын зай 1.15, үсгийн хэмжээ 12; Arial фонтоор /MS Word/ бичигдсэн байх ба зохиогчийн CV буюу товч намтрыг хавсаргасан байна;

5.8. Илтгэл өмнө нь мэргэжлийн сэтгүүл, ном, хэвлэл, цахим орчинд нийтлэгдээгүй байна;

Зургаа. Шагналын сан

I байр	-Өргөмжлөл, 1000 000 /нэг сая төгрөг/
II байр	-Өргөмжлөл, 800 000 /найман зуун мянган төгрөг/
III байр	-Өргөмжлөл, 500 000 /таван зуун мянган төгрөг/

Илтгэл хэлэлцүүлсэн оюутнуудад өргөмжлөл гардуулна.

Холбогдох мэдээлэл авах утас, хаяг:
Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх
Сургалт, судалгааны хүрээлэн
Холбогдох утас: 9977-4281
E-mail: gpo_tri@prokuror.mn